



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 12 сарын 13 өдөр

Дугаар 663

Улаанбаатар хот

┌ Хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай ┐

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаах авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар (Зам тээврийн хөгжлийн сайдын багц) худалдан авсан 4 нэрийн, нийт 498,810,500.00 (дөрвөн зуун ерэн найман сая найман зуун арван мянга таван зуун) төгрөгийн үнэ бүхий автозамын битумын эмульсний үйлдвэрийн тоног төхөөрөмж, нөөцийн савыг хавсралтад заасны дагуу төрийн өмчит компанийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, хавсралтад заасан авто замын засвар арчлалтын компанийн захирал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан, бүртгэлд тусгах асуудлыг шийдвэрлүүлэх;

2.2 Хөрөнгийг зохих хууль, тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

123006919
34-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 1 дугаар сарын 1-ны өдрийн
66-д уугаар тогтоолын хавсралт

АВТО ЗАМЫН ЗАСВАР АРЧЛАЛТЫН КОМПАНИУДЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр	Үзүүлэлт	Ашиглалтад орсон он	Балансын үнэ	Бүртгэх байгууллага
1	Автозамын битумын эмульсний үйлдвэрийн тоног төхөөрөмж	1 цагт 2-6 тн эмульс үйлдвэрлэнэ	2023	184,868,000.00	"Харгуй" ТӨХК
2	Эмульсний нөөцийн сав	10 тн	2023	64,537,250.00	
3	Автозамын битумын эмульсний үйлдвэрийн тоног төхөөрөмж	1 цагт 2-6 тн эмульс үйлдвэрлэнэ	2023	184,868,000.00	"Хархорин АЗЗА" ТӨХК
4	Эмульсний нөөцийн сав	11 тн	2023	64,537,250.00	
Нийт дүн					498,810,500.00
(дөрвөн зуун ерэн найман сая найман зуун арван мянга таван зуун)					